



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БАТШИРЭЭТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2026 оны 01 сарын 22 өдөр

Дугаар 502

Батширээт сум

**Ж.Энхтөрийн цалинг шинэчлэн
тогтоох тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Хөдөлмөрийн тухай хуулийн 56.1, 56.2 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Засгийн газрын 2018 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 382 дугаар тогтоолын 1, 2, 6 дугаар хавсралт, Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 238 дугаар тогтоолын 6 дугаар хавсралт, Эрүүл мэндийн сайдын 2026 оны 01 сарын 14-ны А/11 тушаалын 1, 2, 3 дугаар хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Эрүүл мэндийн төвийн дарга Жамъяны Энхтөрийн үндсэн цалинг ТҮЭМ-6 шатлал буюу 2,026,700 (хоёр сая хорин зургаан мянга долоон зуун) төгрөг, албан хаасан хугацааны нэмэгдлийг 4%, орон нутгийн нэмэгдлийг 40%, хоолны зардлыг ажлын өдөр бүр 10,000 (арван мянган) төгрөгөөр тус тус тооцон цалинг шинэчлэн тогтоосугай.

2. Ж.Энхтөрийн цалинг хуулийн дагуу бодож олгохыг нягтлан бодогч (Э.Ононтунгалаг)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



БАЛТАНГЭРЭЛ

232601003